

**“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03-р сарын 28-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссийн дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлтийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НАРАНЗУЛ

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 28-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны ногдол ашиг хуваарилахгүй талаар батлах

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссийн дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК нь 2023 онд алдагдалтай ажилласан байх ба банкны өмнө хүлээсэн зээлийн гэрээний үүргийн дагуу ногдол ашиг хуваарилахгүй талаар хувьцаа эзэмшигчдэд таницуулсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б. Наранзуул

Б.НАРАНЗУЛ

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 28-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйл, Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссийн дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатайгаар сонгосугай. Үүнд:

а/ ТУЗ-ийн ердийн гишүүд:

1. Баярхүү овогтой Наранзул
2. Баярхүү овогтой Наранцацралт
3. Баасанжав овогтой Мөнхцацралт
4. Баасанжав овогтой Алтанцэцэг
5. Гүндсамбуу овогтой Ганзориг
6. Аюурзана овогтой Чанцалдулам

б/ ТУЗ-ийн хараат бус гишүүд:

7. Шаравсамбуу овогтой Энхтөр
8. Дамдиндагва овогтой Эрдэнэбилэг
9. Өлзийбаяр овогтой Ариунболд

2. ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгохгүй байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.Наранзул

Б.НАРАНЗУЛ

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 28-ны өдөр

№ 04


Улаанбаатар хот

Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4, 55.8 заалтууд, Хувьцаа эзэмшигчдийн тооллогын комиссийн дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөнгөн бетон” ХК-ийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож хэлбэрийг өөрчилсүгэй.
2. Компанийн 1,24%-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны төлбөрийг хөрөнгийн биржийн сүүлийн 6 сарын арилжааны жигнэсэн дундаж ханшаас дээгүүр буюу нэгж хувьцааны үнийг 300 төгрөгөөр тогтоож хувьцаа эзэмшигч бүрийн нэрийн дансанд хувьцааны тоогоор үржүүлж төлбөрийг шилжүүлсүгэй.
3. Компанийн хэлбэр өөрчлөх материалуудыг бүрдүүлэхийг А.Чанцалдулам-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б. Наранзул

Б.НАРАНЗУЛ